



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 417

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг шинэчлэн бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Хаан даатгал” ХХК-ийн “Зорчин явагчийн гэнэтийн ослын даатгал”-ын бүтээгдэхүүнийг хавсралтын дагуу бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Хаан даатгал” ХХК /М.Од/-д үүрэг болгосугай.


3. Тус бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Хаан даатгал” ХХК /М.Од/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ

1.	Даатгалын компанийн нэр:	“Хаан даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Нийтийн тээврээр зорчин явагчийн гэнэтийн ослын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
4.	Даатгалын зүйл	1. Зорчигч тээврийн хэрэгслээр зорчиж буй иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, эрсдэлийн улмаас учрах бусад зардал; 2. Тогтоосон журмын дагуу 0-6 насны тасалбаргүй яваа хүүхэд.
5.	Даатгалын эрсдэл	1. Зам тээврийн аюул осолд өртөх буюу нийтийн тээврийн хэрэгсэл нь замын хөдөлгөөнд оролцож байх үедээ онхолдох, мөргөлдөх болон биет зүйл мөргөх, шарваж гулсаж осолдох, өндөрлөгөөс унах, живэх болон аяллын явцад учирч болзошгүй бусад эрсдэлүүд; 2. Байгалийн эрсдэлүүд буюу хүчит салхи, цасан ба шороон шуурга, цочир хүйтрэлт, хүйтэн бороо, үер усны аюул, газар хөдлөлт, хөрсний нуралт, гулгалт, цөмрөлт, аянга, гал түймрээс үүдэлтэй эрсдэлүүд; 3. Мөн 3.1.2-т заасан байгалийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор замд яваа тээврийн хэрэгсэл, зорчин явагчдыг түр хугацаагаар суурин газарт байрлуулсан, саатуулсан эрсдэл; 4. Улс, хот хоорондын тээврийн хэрэгсэл түр саатан зогссон үед зорчигч бууж явганаар зорчиж байх үедээ элдэв осолд өртсөнөөс үүссэн /тээврийн хэрэгсэлд дайруулах мөргүүлэх, халтирч унах, хоолны хордлого/ эрсдэлүүд.
6.	Даатгалын гэрээний хугацаа	Даатгалын үргэлжлэх хугацаа нь зорчигч зохих тийз, тасалбараа авч тухайн тээврийн хэрэгсэлд суусан үеэс эхлэн аяллын замын турш /түр зогсолт хийн амрах, хооллох, хоноглох зэрэг хамаарна./ үйлчлэх бөгөөд тасалбарт заасан эцсийн газар буух хүртэлх хугацаагаар тодорхойлогдоно
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	11 бүлэг, 97 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/23 тоот шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Д.Энхтайван
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн менежер Б.Цэрэнжамц